



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СТАТИСТИКИЙН ЧАНАРЫН ТАЙЛАН

СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТР

Улаанбаатар 2018 он

АГУУЛГА

1. ОРШИЛ	4
2. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
3. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ, КОД	6
4. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	9
4.1. Үнэн бодит, найдвартай байдал	9
4.2. Цаг хугацаандаа байх, шуурхай байдал	12
4.3. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал	12
4.4. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал	12
4.5. Нийцтэй, харьцуулах боломжтой байдал	13
5. НУУЦЛАЛЫГ ХАНГАСАН БАЙДАЛ	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар

1. ОРШИЛ

Статистикийн бизнес регистрийн мэдээллийг хэрэглэгчдэд зориулсан чанарын тайланг боловсруулан Та бүхэнд хүргэж байна.

Статистикийн бизнес регистр гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ, ажиллагчдын тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг агуулсан мэдээллийн сан бөгөөд уг мэдээллийн санд үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, эрхэлж буй ажил, үйлчилгээний чиглэл, байршлыг үнэн зөв тогтоож, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг нь бодитойгоор тодорхойлох, статистикийн судалгааны хамрах хүрээг тогтоож, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг статистикийн мэдээлэлд хамруулдаг.

Энэхүү чанарын тайлангийн зорилго нь хэрэглэгчид статистикийн бизнес регистрийн сангаас гаргасан тоо мэдээллийг хэрхэн цуглуулж, боловсруулж гаргадаг, мэдээллийн чанар, нууцлал хэрхэн хангагдсан, мэдээллийн чанар, үнэн бодит байдалд хэрхэн хяналт тавьж баталгаажуулдаг талаар нарийвчилсан мэдээлэл өгөх юм.

Нөгөө талаар энэхүү чанарын тайлан нь мэдээллийн хэрэгцээ, ашиглалтыг сайжруулахаас гадна мэдээллийг буруу хэрэглэхээс урьдчилан сэргийлж, улмаар албан ёсны статистикийн мэдээлэлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, статистикийн үйл ажиллагааг ил тод болгох ач холбогдолтой.

Уг тайлан нь 4 бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэг нь бизнес регистрийн мэдээллийг бүрдүүлэх, ашиглах эрх зүйн үндэслэл, давтамж, тархаах хугацаа, хамрах хүрээ, ашигласан арга зүй зэрэг ерөнхий мэдээллийг агуулсан нийтлэг үндэслэл, хоёрдугаар бүлэг нь бизнес регистрийн үндсэн ойлголт, тодорхойлолтыг агуулсан ойлголт, тодорхойлолт, ангилал, гуравдугаар бүлэг нь бизнес регистрийн сангийн үзүүлэлтийн үнэн бодит байдал, цаг хугацаандаа байгаа эсэх, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх, мэдээллийн эх үүсвэр, найдвартай байдал зэргийг агуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт бүлэг, дөрөвдүгээр бүлэг нь бизнес регистрийн сангийн мэдээллийн нууцлалыг хэрхэн хангадаг талаарх тусгасан нууцлал хангасан байдал бүлгүүдээс бүрдэнэ.

2. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Бизнес регистрийн сангийн мэдээлэл нь ААНБ-ын тоог бодитой гаргаж, статистикийн мэдээлэлд бүрэн хамруулах, тэдний байршил эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл, улс орны эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох, статистикийн судалгаа, түүвэр ажиглалтын хамрах хүрээг бүрэн тогтоох суурь мэдээлэл болдог.

Хууль, эрх зүйн үндэслэл:

Дараах тогтоол, шийдвэрийг бизнес регистрийн мэдээллийн сан байгуулах, хөтлөх, ашиглах хууль, эрх зүйн үндэслэл болгосон. Үүнд:

- Үндэсний статистикийн хорооны даргын “Статистикийн бизнес регистрийг байгуулах аргачлал”, “Бизнес регистрийг хөтлөх, ашиглахад баримтлах журам”, “Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн мэдээ БР-1” маягтыг батлах тухай 2018 оны 05-р сарын 16-ны өдрийн А/53 тоот тушаал;
- Олон улсын цогц үнэлгээний тайланд бизнес регистрийг сайжруулах талаар өгсөн гол зөвлөмж;
- Монгол Улсын “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Иргэний тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Хоршооны тухай хууль”, “Нөхөрлөлийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Төрийн бус байгууллагын тухай хууль”, “Улс төрийн намын тухай хууль”, “Байгууллагын нууцын тухай”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”.

Бизнес регистрийн мэдээллийн эх үүсвэр давтамж, хугацаа:

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогын үр дүнд үндэслэн бизнес регистрийн мэдээллийн санг анх байгуулж, бизнес регистрийн улирлын мэдээ, аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын дүн, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газрын бүртгэл, бусад яам, агентлагийн мэдээлэлд үндэслэн улирал тутам шинэчилж байна.

Хамрах хүрээ:

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн нэр, хаяг, регистрийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ,

борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ, ажиллагчдын тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг бизнес регистрийн санд бүртгэдэг.

Бизнес регистрийн 2017 оны мэдээллийн санд бүртгэлтэй 157.1 мянган аж ахуйн нэгж, байгууллагаас 155.1 мянга (98.7%) нь хуулийн этгээд, 1991 (1.3%) нь салбар нэгж байна.

Бизнес регистрийн 2017 оны жилийн эцсийн мэдээллийн санд бүртгэлтэй 155.1 мянган хуулийн этгээдийн 78.6 (50.7%) мянга нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулаагүй 76.5 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 38.1 (49.9) мянга нь үйл ажиллагаа эхлээгүй, 34.2 (44.7%) мянга нь түр зогссон, 1.6 (2.1%) мянга нь бүрэн зогссон, 2.6 (3.3%) мянга нь хаяг тодорхойгүй болон бусад шалтгаантай байна.

Мэдээлэл цуглуулах арга:

Бизнес регистрт аж ахуйн нэгж, байгууллагын өөрчлөлт, хөдөлгөөнийг албан ёсны статистик мэдээлэл болон захиргааны мэдээллийг ашиглан хийдэг.

Албан ёсны статистикийн мэдээлэл: Бизнес регистрийн улирлын мэдээ, эдийн засгийн салбаруудын сар, улирал, жилийн мэдээ, ААНБ-ын тооллого байна.

Захиргааны статистик: Захиргааны мэдээлэл нь бизнес регистрийн сангийн үзүүлэлтүүдийн үнэн зөв эсэхийг хянах, засварлах, шинэчлэх эх үүсвэр болно. Үүнд: ОӨУБЕГ, ТЕГ-ын аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн мэдээллийг хамруулна.

3. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ, КОД

Бизнес регистрийг байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагын өөрчлөлт, хөдөлгөөнийг тусгахдаа дараах ойлголт, тодорхойлолт, ангиллыг ашигласан. Үүнд:

Ойлголт, тодорхойлолт:

Хуулийн этгээд: Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ (Иргэний хууль, 2002-01-10).

Үйл ажиллагаа эрхлэлтийн байдал: Үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг идэвхтэй нэгж, идэвхгүй нэгж гэж ангилах ба идэвхгүй нэгж нь үйл ажиллагаа эхлээгүй, үйл ажиллагаа түр зогссон, үйл ажиллагаа бүрэн зогссон, татан буугдсан нэгжээс бүрдэнэ.

Идэвхтэй нэгж: Тайлант хугацаанд эдийн засгийн хувьд идэвхтэй байсан аж ахуйн нэгж, байгууллагыг ойлгоно. Аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн үйл ажиллагаа явуулахгүй боловч хууль эрхзүй, захиргааны хувьд идэвхтэй байж болно.

Идэвхгүй нэгж: Хуулийн дагуу бүртгэгдсэн боловч эдийн засгийн хувьд үйл ажиллагаа явуулаагүй нэгжийг ойлгоно. Үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

Үйл ажиллагаа түр зогссон: Хоёр жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй боловч цаашид үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг ойлгоно. Хэрэв тухайн аж ахуйн нэгж улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг бол түр зогссон гэж үзэхгүй.

Үйл ажиллагаа бүрэн зогссон: Хоёр жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй, тухайн орон нутгийн бүртгэл болон татварын байгууллагад татан буугдах хүсэлтээ өгсөн, эсвэл татварын байгууллагад татан буугдахаар бүртгэгдсэн аж ахуйн нэгжийг ойлгоно. Өөрөөр хэлбэл татан буугдахаар хүлээгдэж байгаа аж ахуйн нэгжүүд орно.

Татан буугдсан: Дампуурсан, хуулийг удаа дараа ноцтой зөрчсөн, үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан, зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан, нэг ч гишүүнгүй болсон зэрэг үндэслэлээр шүүх татан буулгах шийдвэрийг гаргасан бол татан буугдсан гэж ойлгоно.

Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүртгэлийн санд хуулийн этгээдийг татан буулгаснаар бизнес регистрийн санд бүртгэдэг.

Үндсэн үйл ажиллагаа: Тухайн нэгжийн нийт нэмэгдэл өртгийн ихэнх хувийг бүрдүүлж байгаа, “ихээс бага руу хуваарилах” ОУ-ын ангиллын дүрмийн дагуу тодорхойлогдсон хамгийн дээд түвшний үйл ажиллагааг ойлгоно.

Хоёрдогч үйл ажиллагаа: Үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг хоёрдогч үйл ажиллагаа гэж үзнэ.

Борлуулалтын орлого: Бараа, бүтээгдэхүүний өмчлөх эрхийг бусдад төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэсний орлого юм.

Ажиллагчид: Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг байдал (статус)-д хамрагдаж буй иргэнийг ойлгоно.

Хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, үүсэн байгуулагдсан хэлбэр: Хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, үүсэн байгуулагдсан хэлбэрийг хуулийн этгээдийн бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүртгэлийн мэдээллийн санд үндэслэн холбогдох хууль, тогтоомжийн дагуу тодорхойлно.

Ангилал, код:

Бизнес регистрийн мэдээллийн сангийн үзүүлэлтийн ангилал, кодыг олон улсын зөвлөмж, төрийн захиргааны бусад байгууллагуудын захиргааны мэдээллийн санд мөрдөж буй албан ёсны ангилал, кодтой нийцүүлэн ашигладаг. Үүнд:

- **Монгол Улсын бүсчлэлийн код, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код:** Стандартчилал, хэмжилзүйн газрын 2006 онд гаргасан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код.
- **Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (5 оронгийн түвшинд):** Сангийн сайдын 2011 оны 04-р сарын 29-ний өдрийн 103 тоот тушаалын 1-р хавсралт.
- **Хариуцлагын хэлбэрийн ангилал:** Компанийн тухай Монгол Улсын хууль, Хоршооны тухай Монгол Улсын хууль, Нөхөрлөлийн тухай Монгол Улсын хууль зэрэг хууль тогтоомж.
- **Өмчийн хэлбэрийн ангилал:** Компанийн тухай Монгол Улсын хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай Монгол улсын хууль, бусад хууль тогтоомж.
- **Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан хэлбэр:** Компанийн тухай Монгол Улсын хууль.
- **Төрийн бус байгууллагын чиг үүргийн ангилал:** ҮСХ-ны даргын 2011 оны 04-р сарын 14-ний өдрийн 01/55 тоот тушаалаар батлагдсан ангилал.
- **Эдийн засгийн секторын ангилал:** ҮСХ-ны даргын 2015 оны 02-р сарын 18-ны өдрийн А/26 тоот тушаалаар батлагдсан ангилал.

4. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Бизнес регистрийн мэдээллийн сангийн чанарын үзүүлэлтийг ҮСХ-ны чанарын баримт бичигт тусгасан дараах шалгуур үзүүлэлтээр тодорхойллоо.

4.1. Үнэн бодит, найдвартай байдал

Бизнес регистрийн мэдээллийн санд ААНБ, түүний салбар нэгжийн хамруулж, мэдээллийг үнэн бодитой, найдвартай байлгах үүднээс дараах зарчмуудыг баримтлан ажиллалаа. Үүнд:

ААНБ-ыг бүрэн хамруулах чиглэлээр:

- Бизнес регистрийн санд шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар нэгж, төлөөлөгчийн газрын мэдээллийг тухайн нэгж бүртгэгдсэн улиралд багтаан нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн бизнес регистр хариуцсан ажилтнууд БР-1, 2 маягтаар авч мэдээллийн санд нэмэлт өөрчлөлтийг тусгасан. Шинээр бүртгэгдэх нэгжийг тодорхойлохдоо дараах шалгалтыг хийсэн. Үүнд:
 - **Нэр, байршлаар нь шалгах:** Хоёр өөр регистрийн дугаартай хуулийн этгээд нь ижил нэртэйгээр нэг хаяг дээр үйл ажиллагаа явуулж байгаа эсэх.
 - **Нэр, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр нь шалгах:** Хоёр өөр регистрийн дугаартай хуулийн этгээд нь адил нэртэй, ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэх.
 - **Байршил, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр нь шалгах:** Хоёр өөр регистрийн дугаартай хуулийн этгээд нь нэг хаяг дээр ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэх.
- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нэгжийн хувьд тайлант хугацааны санхүү, татварын сар, улирал, хагас, бүтэн жилийн тайлан, мэдээнд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг ҮСХ-ны бизнес регистр хариуцсан ажилтнууд тодорхойлж, нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн салбар хариуцсан ажилтнууд өөрийн газар, хэлтсийн бизнес регистр хариуцсан ажилтантай хамтран үйл ажиллагаа эрхлэлтийн байдал, үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тоо, хаягийн мэдээллийг авч бизнес регистрийн санд тусгасан.

Мэдээллийн чанарын асуудлаар:

- Бизнес регистрийн мэдээллийг чанарыг сайжруулах, хамралтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хүрээнд ТЕГ-тай байгуулсан санамж бичиг, ОӨУБЕГ-тай байгуулсан мэдээлэл солилцох гэрээний дагуу ТЕГ-ын татвар төлөгчийн мэдээлэл, ОӨУБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг Үндэсний дата төвөөр дамжуулан тогтмол авах үйл ажиллагааг хэрэгжүүллээ.
- Бизнес регистрийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар хэлтсийн бүх ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт өөрийн хариуцсан салбарын бизнес регистрийн мэдээллийг засварлах, сайжруулах тухай ҮСХ-ны даргын албан тоотыг хүргүүлсэн.
- Бизнес регистрийн мэдээллийн санд дараах шалгалтыг хийж, өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:
 - Логикийн болон балансын алдаа
 - Үзүүлэлт дутуу нөхөх
 - Ангиллын код буруу оруулах
 - Бусад мэдээллийн эх үүсвэрүүдтэй уялдсан байдлыг шалгаж, холбогдох тодруулга, засвар өөрчлөлтийг тусгах

Сургалт:

Бизнес регистрийн чанарыг сайжруулах, салбар хариуцсан ажилтны чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Бизнес регистрийн чанарын сайжруулалт, програм хангамж ашиглалт” онлайн сургалт хийх хуваарь гаргаж, нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн 150 орчим ажилтанг хамруулж, зохион байгууллаа.

- Бизнес регистрийн талаарх ерөнхий ойлголт;
- Бизнес регистрийг хөтлөх, ашиглах;
- БР-ийн хөдөлгөөнт мэдээллийн сан удирдах програм хангамж ашиглах;
- БР-ийн улирлын мэдээллийн сан удирдах програм хангамж ашиглах;

Хяналт, шалгалт, мониторинг:

ҮСХ-ны Бизнес регистрийн албанаас бизнес регистрийн мэдээний цуглуулалт, хамралт, үнэн бодит байдалд үнэлгээ хийж, бизнес регистр хариуцсан албан тушаалтны үйл ажиллагаа, бусад салбар хариуцсан ажилтнуудын бизнес регистрийн үйл ажиллагаанд оролцож буй байдалд хяналт хийх, заавар, зөвлөмж өгөх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хамтарч шийдвэрлэх зорилгоор Нийслэлийн төвийн зургаан дүүрэгт дараах чиглэлийн дагуу хяналт тавьж ажилласан. Үүнд:

- Хэлтсийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөтэй танилцаж, ҮСХ-ны даргын 2018 оны 01-р сарын 09-ний өдрийн 01/21 албан тоотын хэрэгжилт;
- Мэдээний ирцийн бүртгэл, түүнийг ажлын үр дүнгийн үнэлгээнд тооцож байгаа байдал;
- Анхан шатнаас ирсэн мэдээ, тайлангийн үнэн зөв, шуурхай байдалд хяналт тавьж байгаа байдал;
- Бизнес регистрийн мэдээ, тайланд Статистикийн газар, хэлтсийн даргаас үзүүлж буй дэмжлэг, мониторинг;
- Бизнес регистр хариуцсан ажилтан болон улсын байцаагчийн ажлын уялдаа;
- Бизнес регистрийн улирлын мэдээний асуулгын хуудасны архивлалт, материалын хадгалалт, стандарт мөрдөж байгаа байдал;
- Бизнес регистрийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагаа, бизнес регистрийн мэдээ, тайланг хэрхэн гаргаж байгаатай танилцах;
 - Мэдээллийг БР-1, 2 маягтаар бүрэн гүйцэд, үнэн зөв хүлээн авч, баримтжуулж байгаа эсэхийг шалгаж, мэдээллийн сантай тохирч байгаа эсэхийг хянах;
 - Бизнес регистрийн мэдээний хүрээ, түүний хамралтыг тэмдэглэсэн файл нь компьютерт, жил, улирлаар эмх цэгцтэйгээр хадгалагдаж баримтжуулсан эсэх;
 - Бөглөгдсөн маягтын үзүүлэлт, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хэрхэн шалгаж, хяналт хийж эсэх;
 - БР-1, 2 маягтын дагуу үзүүлэлт тус бүрээр цуглуулж байгаа эсэхийг хянах зорилгоор сонгогдсон 1-2 нэгжтэй холбогдож, маягтын дагуу харьцуулж шалгах;

- Бизнес регистрийн санд тусгах аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн өөрчлөлтийг төвөөс тодруулга хийх хүсэлт тавихыг хүлээлгүй тухай бүрт нь хийж байгаа эсэх;
- Бизнес регистрийн сангийн жилийн тодруулга хийх ажлын зохион байгуулалт, тулгарч буй хүндрэлтэй асуудал, санал;
- Засаг захиргааны нэгжид орсон өөрчлөлт (гудамж, хорооны нэр, дугаар)-ийг тухай бүрт ҮСХ-нд мэдээлж, БР-ийн санд тусгуулж байгаа эсэх;
- Мэдээллийг онлайнаар шивэх, мэдээний явцад тулгарч байсан хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх санал;
- Мэдээний үнэн бодит байдлыг аль түвшинд хэрхэн шалгаж, баталгаажуулж байгаа байдал;
- Бизнес регистрийн боловсруулалтын програмын ашиглалтын байдал, тулгарч буй асуудлууд;
- Бизнес регистрийн чиглэлээр танилцуулга хийж буй эсэх.

4.2. Цаг хугацаандаа байх, шуурхай байдал

ҮСХ-ноос баталсан мэдээлэл тархаах хуваарийн дагуу бизнес регистрийн мэдээллийг улирал бүр тархааж байна.

4.3. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал

Бизнес регистрийн сангийн мэдээллийг улирал, жилийн давтамжтай хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархааж байна. Мөн түүнчлэн хэрэглэгч албан бичгээр болон өөрийн биеэр хандах, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээлэл авч байгаа болно.

Бизнес регистрийн сангийн мэдээлэл нь судалгааны байгууллага, судлаач нарт түүвэр судалгааны эх олонлог болгон ашиглах ганц эх үүсвэр болдог тул “Бизнес регистрийг хөтлөх, ашиглахад баримтлах журам”-д аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хаягийн мэдээллийг холбогдох гэрээ хийсний үндсэнд ашиглуулж болох тухай тусгасан.

4.4. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал

ҮСХ-ны бүх хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр адил тэгш хангах зарчим баримталдаг бөгөөд хуулийн хүрээнд бүх мэдээлэл хэрэглэгчид нээлттэй, ил тод байдаг хэдий ч аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл нь нууцад хамаарна. Иймд бизнес регистрийн сангийн мэдээллийг хүснэгт, текст, график дүрслэл хэлбэрээр

тархаахаас гадна статистик мэдээллийн үйлчилгээний нэгдсэн систем www.1212.mn сайтад байрлуулан нийтэд үнэ төлбөргүйгээр хүргэж байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, тэдгээрийн ажиллагчдын тоог 10 жилийн динамикаар харуулсан “Статистикийн бизнес регистр-2017” сэдэвт танилцуулгыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал (4.0 хувилбарын дагуу)-ын дагуу боловсруулан www.1212.mn сайтад байрлуулан хэрэглэгчдэд тархааж байна.

4.5. Нийцтэй, харьцуулах боломжтой байдал

ҮТС-2008 (ҮСХ, 2013), “Статистикийн бизнес регистрийн гарын авлага” (UN, 2015), “Статистикийн нэгжийн гарын авлага” (UN, Statistical units, 2007), “Бизнес регистрийн талаарх зөвлөмж” (Eurostat, 2010), “Африкийн орнуудад статистикийн бизнес регистрийг байгуулах гарын авлага” (ADB, 2014) болон Монгол Улсын Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Компанийн тухай хууль зэрэгт үндэслэн боловсруулсан “Статистикийн бизнес регистрийг байгуулах аргачлал”, “Бизнес регистрийг хөтлөх, ашиглахад баримтлах журам”-ын дагуу бизнес регистрийн мэдээллийн сангийн хөтлөлт, өөрчлөлтийг тогтмол хийж, үр дүнг дараах үзүүлэлтээр улирлын давтамжтай тархааж байна.

- Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоог байршил (аймаг, сум), эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал (3.0 хувилбарын дагуу), хариуцлагын хэлбэрээр, үйл ажиллагаа эрхлээгүй шалтгаанаар;
- Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог байршил (аймаг, сум), эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хариуцлагын хэлбэрээр.

5. НУУЦЛАЛЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Монгол Улсын “Байгууллагын нууцын тухай”, “Хувь хүний нууцын тухай”, “Статистикийн тухай” хууль, ҮСХ-ны “Мэдээллийн нууцын журам”-д заасны дагуу бизнес регистрийн сангийн мэдээлэл нь аж ахуйн нэгж, байгууллагын нууцад хамрагдах бөгөөд бизнес регистр хариуцсан ажилтнууд нь ААНБ-ын мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээдэг.

Тухайлбал, “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу албан ёсны статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг

байгууллагын ажилтан албан ёсоор мэдээлэх түвшинд хүрээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахыг хориглоно гэж заасан.

ҮСХ, нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн бизнес регистр хариуцсан ажилтнууд нь бизнес регистрийн санд өөрийн нэвтрэх нэр, нууц үгээр нэвтэрч, өөрийн эрхийн хүрээнд мэдээллийг засварлах, мэдээлэл нэмэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт авах орон нутгийн статистикийн газар, хэлтсийг ажилтнуудын эрхийг хааж, мэдээллийн нууцыг хамгаалж, уг мэдээллийг хуулбарлах, бусад хувь хүн, байгууллагад мэдээлэх, мэдээллийн нууцыг задруулахыг хатуу хориглосон байдаг.

Бизнес регистрийн мэдээллийн сангийн нууцлалд хамаарагдах үзүүлэлтэд аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээрх ажиллагчдын тоо, борлуулалтын орлого, хөрөнгийн хэмжээ зэрэг эдийн засгийн үзүүлэлтийг хамруулсан.

Бизнес регистр хариуцсан ажилтнуудад аж ахуйн нэгж, байгууллагын талаарх олж авсан мэдээллийн талаар хоорондоо ярилцахгүй байх, гэр бүл, хамаатан садан, найз нөхдөдөө ярихгүй байх, аж ахуйн нэгжийн санхүүгийн мэдээллийг татвар, санхүү гэх мэт бусад төрийн байгууллагын ажилтанд мэдээлэхгүй байх үүрэг хүлээдэг.

Энэхүү чанарын тайлантай холбогдолтой асууж, тодруулах зүйлээ information@nso.mn хаягаар болон 51-261567 утсаар лавлана уу.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР